



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/489

Улаанбаатар хот

**Эд хөрөнгө балансаас баланст
шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/227 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 7,603,205,342.31 (долоон тэрбум зургаан зуун гурван сая хоёр зуун таван мянга гурван зуун дөчин хоёр төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 7,041,266,957.19 (долоон тэрбум дөчин нэгэн сая хоёр зуун жаран зургаан мянга есөн зуун тавин долоон төгрөг арван есөн мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй эд хөрөнгийг “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Балансаас балансад шилжин ирж буй хөрөнгийг актаар хүлээн авч, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК (Н.Баярчимэг)-д үүрэг болгосугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Н.Уранчимэг), “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК (Н.Баярчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001309



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/189 тоот тушаалын хавсралт

Балансаас баланст шилжүүлэх барилга байгууламжийн жагсаалт

№	Байгууламжийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл/2021.11.30./	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгуулага
1	33 4-р байр УБ Бизнес хөгжлийн төв	1991	ш	1	7,457,777,192.31	514,329,461.52	6,943,447,730.79	
Барилга байгууламжийн дүн					7,457,777,192.31	514,329,461.52	6,943,447,730.79	
1	К80-200 усны насос/УББХТ/	2002	ш	1	2,500,000.00	1,270,833.04	1,229,166.96	
2	Хандог лифт БХТөв	2002	ш	1	62,328,385.00	30,050,225.31	32,278,159.69	
3	Халаалтын мотор УББХТ	2002	ш	1	2,500,000.00	1,104,166.37	1,395,833.63	
4	Электрон лед дэлгэц УББХТ	2004	ш	1	21,200,000.00	8,780,000.26	12,419,999.74	
5	Анонс өлгөдөг суурь УББХТ/гадаа/	2004	ш	1	1,320,000.00	517,000.00	803,000.00	
6	НТЗ-4- байр павьлон	2020	ш	1	32,109,265.00	5,886,698.62	26,222,566.38	
7	2-р давхарын цахилгаан халаалт	2021	ш	1	23,470,500.00	-	23,470,500.00	
Тоног төхөөрөмжийн дүн					145,428,150.00	47,608,923.60	97,819,226.40	
НИЙТ ДҮН					7,603,205,342.31	561,938,385.12	7,041,266,957.19	

/төгрөгөөр/

Нийслэлийн өмчит
"Улаанбаатар хотын
хөгжлийн корпораци" ХК